



**НИЙСЛЭЛИЙН  
НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 5/д3

Улаанбаатар хот

Зарим албан хаагчдад нэмэгдэл  
цалин хөлс олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.12, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”, Нийслэлийн Онцгой комиссын даргын 2021 оны 03 сарын 10-ны өдрийн 08 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/817 дугаар захирамжаар баталсан “Нийтийн тээврийн үйлчилгээний газрын дүрэм”-ийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалын эрсдлийг бууруулах, тэмцэх, хариу арга хэмжээ авах, шуурхай ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий Нийслэлийн Онцгой комиссын “Шуурхай штаб”-ын бүрэлдэхүүнд 2021 оны 2 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн илүү цагаар ажиллаж буй Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтсийн Ахлах мэргэжилтэн Цэрэндондогийн Наранцэцэг, Ачаа тээвэр авто үйлчилгээний хэлтсийн Ахлах мэргэжилтэн Чойжилсүрэнгийн Ариунтуяа нарын илүү цагийн хөлсийг хавсралтаар баталсугай.

2. Илүү цагийн хөлсийг цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас тооцож олгохыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн Ахлах нягтлан бодогч /Э.Эрдэнэтуяа/-д зөвшөөрсүгэй.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс /М.Мөнхбаяр/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.САЙХАНБАЯР

Нийтийн тээврийн үйлчилгээний  
газрын даргын 2021 оны 03 дугаар  
сарын 13-ны өдрийн 5/23 дугаар  
тушаалын хавсралт



Нийслэлийн Онцгой комиссын “Шуурхай штаб”-ын бүрэлдэхүүнд  
ажиллаж буй албан хаагчдын илүү цаг

Д/д	Албан хаагчийн овог, нэр	Албан тушаал	Албан тушаалын ангилал, зэрэглэл, шатлал	Үндсэн цалин	Илүү цаг		Нийт бодож олгох илүү цаг
					2 сар	3 сар	
1	Ц.Наранцэцэг	Ахлах мэргэжилтэн	ТЗ-6-5	853,375	102	40	142
2	Ч.Ариунтуяа	Ахлах мэргэжилтэн	ТЗ-6-5	853,375	86	40	126

---oOo---